

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**  
**“МОНГОЛ СУДЛАЛ”**

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244804

**МОНГОЛ, СОЛОНГОС ХЭЛНИЙ “ХҮРЭХ/당다” ХЭМЭЭХ ҮЙЛ ҮГИЙГ  
ТАНИН МЭДЭХҮЙН ТҮВШИНД ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ**

Б.Болормаа

**Хураангуй:** Танин мэдэхүйн хэл шинжлэл нь үгийн утга хүний тархинд хэрхэн үүсэж бүрэлдсэнийг судалдаг бөгөөд хүний хийсвэрлэх сэтгэхүйн өргөн хүрээг илрүүлэхийн тулд судалгааны эргэлтэд хараахан ороогүй байгаа хүртэх үйлийн үндсэн үг болох “хүрэх/당다” үйл үгээр гол болгон түүний шилжмэл болон ойролцоо утгын эгнээ, хүрээ хэрхэн бүрэлдэж байгааг монгол, солонгос хэлнээ харьцуулан судаллаа.

Орчин үеийн танин мэдэхүйн судалгаагаар монгол болон солонгос хэл нь хэв шинжийн хувьд үйл үг төвт хэл бөгөөд энэ хэлнүүдэд чиглэл, орон байр заах тусгай үг байдаггүй гол төлөв тухайн үйл үгээрээ хамтад нь буюу утга зүйн хүрээгээр илэрхийлдэг онцлогтой. Энэхүү онцлогийг нийлмэл бүтцийн хүрээнд авч үзвэл шилжмэл утга болон ойролцоо утгын үүсэл маш тодорхой харагдах бөгөөд монгол болон солонгосчуудын сэтгэлгээний ялгааг ч жишээгээр батлан харуулав.

Монголчууд “хүрэх” хэмээх үйл үгээр аливаа юм ойртох, тулж ирэх гэсэн утгаас оюуншуулан хийсвэрлэж тэрхүү мэдрэмж өөрт мэдрэгдэж буйг “нойр хүрэх”, “уур хүрэх” гэхчлэн илэрхийлдэг бол солонгос хүний сэтгэлгээнд тэр мэдрэмж дотроос гадагшаа чиглэн гардаг тул “нойр ирэх”, “уур гарах” хэмээн сэтгэн илэрхийлдэг болох нь хэлний баримтаас харагдав. Мөн солонгос хэлэнд “당다” хүрэх гэсэн үйл үгээр холбоо харилцаа илтгэсэн үг багагүй байсан бол монгол хэлэнд мэдрэмж, сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгс цөөнгүй байгаа ялгаа ажиглагдлаа.

**Түлхүүр үг:** танихуй, хүртэхүй, сэтгэлгээ, оюуншуулал, хүрэх, харьцуулах

**Оршил**

Хүний идэвхтэй үйл хөдлөл нь хүрээлэн байгаа гадаад ертөнцийг танин мэдэх үндэс болдог. Хүн таван мэдрэхүйн эрхтнээрээ дамжуулан аливаа эд юмс үзэгдэл тэдгээрийн хэлбэр дүрс өнгө, шинж чанарыг таньж мэддэг. Хүний өөрийн биед байх нүд, ам, гар, ам, чих гэсэн таван мэдрэхүйн эрхтний оролцоотойгоор танин мэдэж, түүнийгээ сэтгэхүйдээ туршлага болон хуримтлуулна. Хуримтлуулсан мэдлэг туршлагаа хэрэгцээтэй цагт хийсвэрлэн сэтгэж бодит ахуйд буцаан хэрэглэнэ.

Танин мэдэхийн үндэс юу байв гэдэг талаар “Хүн төрөлхтний хөгжил, ялангуяа ухаант хүний сэтгэхүй сэтгэлгээний нэн балар үеийн төлөв байдлын үүднээс үзвэл хөдөлгөөний төгсгөл нь чухамдаа хүрэх гэгч байсан болов уу хэмээн таамнан ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл, хөдөлгөөн бол хамгийн ерөнхий утгаараа “хөгжлийн үндэс” болдог гэвэл аливаа хөдөлгөөн нь сэдлээс

шалтгаацсан хамааралтай байх нь гарцаагүй юм” (Өнөрбаян.Ц, 2022) гэж тодорхойлсон байдаг.

Иймээс бид уг судалгаандаа үйл үг тэр дундаа хүртэж танин мэдэхийн эхлэл болох “хүрэх” хэмээх үйл үгийг монгол болон солонгос хоёр хэлний орчин үеийн жишээ баримт дээр судалж танихуйн ялгаатай болон төсөөтэй талыг илрүүлэхийг зорив.

Танихуйн хэл шинжлэлийн орчин үеийн ойлголтоор нийт хэлийг хэв шинжийнх нь үүднээс үндсэн хоёр бүлэгт хуваан үзэж байна. Энэ нь дагуул хүрээт хэл (Satellite-frame<sup>1</sup> ба үйл үг төв (verb-centered or verb-framed)<sup>2</sup>-тэй й хэлнүүд гэсэн ангилал юм. Үйл үг нь өөрөө маш өндөр чадвартай бөгөөд үйл ажиллагааны чиглэл, дүр байдал, үйл явц болон түүний үр дүнгийн талаарх ихэнх мэдээллийг агуулдаг (Talmy.L, 2000) гэж тодорхойлсон байдаг.

Харин Lakoff.G (1992) мөн цаг хугацаа, орон зайн цогц ойлголтын холбоо хамаарлыг тайлбарлахдаа цаг хугацаа хөдөлгөөн болон эд юмсын байршил, орон зайнаас хамаарч зүйрлэн төсөөлөгдөж, цогц ойлголтоор илэрч байгаа нь бидний харааны тогтолцоонд хөдөлгөөн буюу байршил мэдрэгч байдаг гэх биологийн сэрэл, мэдрэмжтэй холбоотой юм хэмээжээ (Отгон-Эрдэнэ.Э, 2023).

Орон зай ба цаг хугацааны ухагдахуун нь хүний ертөнцийн тухай ойлголт буюу дүр зургийн гол суурь болдог тул тухайн хэл соёлын өвөрмөц сэтгэлгээг тодорхой хадгалсан байдаг. Орон зай ба цаг хугацааны утга илтгэдэг хэрэглүүрийн утга зүйн онцлог хэл болгонд өөр өөр байдаг. Гэвч танин мэдэхүйн утга зүй ихэнх хэлд цаг хугацаа шиг хийсвэр ойлголтыг илтгэхдээ бодит орон зайн утгын тогтолцоог ашигладаг гэж үздэг. Тийм учраас цаг хугацааны утгыг ч орон зайтай харьцсан хүний биеийн туршлагад үндэслэн тайлбарладаг бөгөөд орон зайн утга зүйн тогтолцоог хүний хийсвэрлэн сэтгэх нэг суурь хэмээн чухалчлан үздэг (이승은, 2023).

Монгол болон солонгос хэл нь үйл үг төвт хэлний бүлэг багтах тул чиглэл болоод орон байр заасан туслах үг, угтвар үг байхгүй бөгөөд харин тухайн үндсэн үйл үгээрээ орон зай, чиглэлийн утгыг хамтад нь илрүүлдэг онцлогтой байна. Тиймээс бид “хүрэх” үйл үгийг танихуйн үүднээс судлахыг зорьж танихуйн үйл нь хэрхэн, ямар үйл явцын дагуу бий болдог талаар дараах хэсэгт харуулав.

Хүний танин мэдэх үйл ажиллагаа өргөжиж, шинээр таньж мэдсэн зүйлээ хэлнийхээ зүй тогтолд нийцүүлэн нэрлэх хэрэгцээ шаардлага аяндаа гарч байна. Танин мэдэхүйд суурилан үндсэн утгын хүрээг өргөжүүлж утгыг шилжүүлэн дүрслэх аргаар үг бүтээж үгийн санг баяжуулах нь түгээмэл дэлгэрсэн арга юм. Бодит оршин байгаа амьтан, юм, хүн, ургамал, хийсвэр юм, үзэгдэл, ойлголтын тодорхой шинжийг ажигласны үр дүнд адил төстэй талыг үндэслэн тэдний нэрээр аливаа зүйлийг нэрлэдэг. Ийм ч учраас эдгээр утга нь цөм шилжсэн утга юм (Туяа.Д, 2020) гэж тодорхойлдог бол бид судалгаандаа шилжсэн утгын хүрээнд ажиглалт хийн судлав.

<sup>1</sup> Satellite хэмээх англи үгийг монгол хэлнээ “хиймэл дагуул” гэж орчуулдаг боловч бид хэл шинжлэлийн нэр томъёонд “дагуул” хэмээн хэрэглэлээ

<sup>2</sup> үйл үг хүрээтэй хэл

**Монгол хэлний “хүрэх” үйл үгийн шилжмэл утгын судалгаа:** Танин мэдэхүйн хүртэж мэдрэх үйл явц нь хүн өөрийн биеийн хүртэхүйн эрхтэн болох арьс болон гараараа аливаа зүйлд хүрэлцэж түүний шинж чанар, төлөв байдлыг мэдэх бөгөөд энэ үйлдлийг “хүрэх” үйл үгээр төлөөлүүлэн авч үзнэ.

Танин мэдэхүйн судалгаанд үйл үгийг нэгээс нөгөөд шилжих үйл явцыг илэрхийлэхийн сацуу Lakoff. G. “эхлэх цэг, туулах зам, хүрэх цэг” гэсэн чиглэлийн туршлагад тулгуурлан “Бид хаа нэг тийшээ явахад эхлэх цэг ба дуусах цэг гэж байдаг. Эхлэх цэг болон дуусах цэгийг зам холбодог” (Lakoff, 1987) гэжээ. Орон зайн хувьд зорьсон газрыг “зорилго (goal)”, харин “очих газар (destination)” гэдэг бол зорилго (purpose) нь очих газраар тодорхойлогдож, зорилгоо биелүүлэх эхлэх цэгээс дуусах цэг хүртэлх замыг туулах (КимЫнЖон, 2023) хэмээн тодорхойлж байна.

“Хүрэх”-ийн шилжсэн утга нь аливаа юм ойртох, тулж ирэх гэсэн утгаас оюуншуулан хийсвэрлэж олон утга үүсгэжээ. “Хүрэх”-ийн үндсэн утгыг “сэрэл мэдрэмж, сэдлээр өдөөгдсөн ямар нэг юм руу хөл, гар мэт бие эрхтэн, эсвэл түүнтэй үүргээр нь адилтган үздэг сэтгэл санаа, ухаан бодлоороо чиглэн хөдөлсөөр зорин чиглэж буй уг юмандаа мөнөөх бие эрхтэн, сэтгэл санаагаараа хавьтах, тулах үйлийг хүрэх гэдэг (Өнөрбаян.Ц, 2022) хэмээх тодорхойлолт бол танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс авч үзсэн бидний судалгааны зорилготой ойролцоо байна.

Бидний өдөр тутмын ярианы хэлэнд “гар хүрэх” гэдэг үгийг хэрэглэж байдаг. Энэ үг ямар сэтгэлгээний үр дүнд үүссэн бэ гэдгийг хайж толь бичгээс шүүрдвэл, **“Гар хүрэх”** (손을 대다 [суныл дэда]) Юманд гараа хүргэх буюу бусдын биед халдаж бага зэрэг жанчих, б. Идээ зөвхөн амсах утгатай (МХТТ). “Хүрэх” үйл үгийн бодит утгаар шилжсэн жишээ ховор бөгөөд “гар хүрэх” нь зодох, жанчих гэсэн утгатай.

Жишээлбэл “Хүчирхийллийн талаарх бидний төсөөлөл гар хүрэх, зодох зэрэг бие махбодын болон бэлгийн хүчирхийллээр хязгаарлагддаг.” (gogo.mn) энэ нь биед халдаж зодох гэсэн утга илэрхийлсэн байна. Харин солонгос хэлэнд энэ үгийг 때리다 [дэрида] буюу зодох цохих гэсэн үгээр илэрхийлнэ. Харин юманд хүрэх гэсэн утгыг 손을 대다 [суныл дэда] гэдэг үгээр илэрхийлэх бөгөөд энэ нь шилжсэн утгаараа 남의 물건에 무단히 손을 대다 [намэ мүлгонэ мүданхи суныл дэда] Бусдын эд зүйлсэд зөвшөөрөлгүй гар хүрэх. Өөр нэг утга нь 정치에 손을 대다 [жончиэ суныл дэда] гэвэл улс төрд оролцох гэсэн утгатай болдог. Харин идээ амсах утгыг 맛을 보다 [масыл буда] амтыг нь үзэх гэсэн үгээр тус тус илэрхийлдэг байна.

Харин **“Аминд хүрэх”** нь алах гэсэн утгатай бөгөөд амь бол маш хийсвэр ойлголт бөгөөд амьд явахын үндэс атал түүнд хүрснээр амьгүй болно хэмээн хийсвэрлэсний үр дүн юм. Жишээ нь “Тэр гурван хүний учрыг мэдэв үү чи? Тэдний царай сэжиглэмээр байна. Чиний аминд хор хүргэж болно. Амьд мэнд үлдвэл эхнэрийг олоход бэрхгүй. (МУЗД<sup>3</sup>:-211) гэснээс үзвэл чамайг хөнөөж болзошгүй гэсэн утга илтгэж байна.

<sup>3</sup> “Монголын уран зохиолын дээжис-108”, 2005

“Хүрэх” хэмээх үйл үг нь дангаараа олон утга үүсгэж чадахгүй тул нийлэмж үгийн бүрэлдэхүүнд орж утгын ялгаа нь тодорч байгаа тул утгын хүрээгээр нь авч үзэж 40 гаруй нийлэмж үгийг дараах байдлаар ангилан үзлээ.

#### **а. Сэтгэл хөдлөл илэрхийлэх**

Хүний зан араншинтай холбоотой үгсийг “хүрэх”-тэй нийлэмж үгээр илэрхийлсэн нь айдас хүрэх, , инээд хүрэх, дур хүрэх, дургүй хүрэх, зэвүү хүрэх, уур хүрэх, цухал хүрэх, залхуу хүрэх, хорхой хүрэх, эгдүү хүрэх, хөх инээд хүрэх, сэжиг хүрэх, хайр хүрэх, зүрхэнд хүрэх гэж хэлж, ярьдаг нь хамгийн давтамж, хэрэглээ өндөртэйгөөрөө энэ бүлэгт багтаж байна. Энэ бүлгийн үгс нь тухайн мэдрэмж төрөхийг “хүрэх” гэдэг үгээр илэрхийлж буй нь өвөрмөц. Харин үйл үгийн чиглэл заасан утга буюу “ойртох” гаднаас дотогш чиглэх гэсэн шинжээ хадгалж буйг анзаарч болно. Тус дэд айг мөн үнэлэмжээр нь дотор нь эерэг, сөрөг үнэлэмж илэрхийлсэн үг гэж ангилах боломжтой.

##### ***1) Сөрөг үнэлэмж илэрхийлсэн үгс***

Сөрөг үнэлэмж илэрхийлэх үгс нь муу мэдээ болон, хүний сэтгэлд таагүй байдал үүсгэх үгийг багтааж байна. Үүнд “айдас хүрэх” (겹이 나다), “дургүй хүрэх” (싫증이 나다), “зэвүү хүрэх” (혐오하는 마음이 생기다), “уур хүрэх” (화가 났다-화가 나다), “залхуу хүрэх” (게으름이 났다-피가 나다, 게으르다), “эгдүү хүрэх” (혐오하다) зэрэг үгс багтана. Монгол хэлний “**айдас хүрэх**” (겹이 나다) нь айх мэдрэмж төрөх, болгоомжилж бэрхшээх гэсэн утгатай. Жишээлбэл “*Хүн танихгүй тэр хол газар явахаас айдас хүрнэ.*” (МУЗД:175) гэж хэлдэг бол солонгос хэлэнд айдас хүрэхийг 겹이 나다 [коби нада] буюу айдас гарах гэсэн үйл үгээр илэрхийлнэ. Жишээнээс харвал монгол хэлэнд айдас хүрэх буюу “ойртох бий болох” гэсэн утгатай бол солонгос хэлэнд “айдас гарах” гэсэн нь айдас биеэс гадагшлах гэсэн утгаар нэрлэснээрээ хоёр хэлэнд чиглэлийн хувьд эсрэг тэсрэг байдлаар шилжсэн утга үүссэнийг харуулж байна.

Энэ мэтээр монгол хэлэнд “хүрэх” гэсэн үгээр илэрхийлсэн үгсийг солонгос хэлнээ “гарах” гэсэн үгээр илэрхийлдэг байна. “**бөөлжис хүрэх**” (멀미가 나다[молмига нада]) нь дотор эвгүйтэж бөөлжихийг хүсэх мэдрэмжийг хэлж байгаа. Гэвч сэтгэл хөдлөл илэрхийлсэн тэр дундаа сөрөг мэдрэмж илэрхийлсэн ангилалд “бөөлжис хүрэх” нь дахин хийсвэрлэгдэж муухай жигшмээр гэсэн утга илтгэдэг учир уг ангилалд хамааруулан үзэв. Жишээлбэл “*Санахаас бөөлжис хүрээд байна.*” (ТТ<sup>4</sup>III:165) бодохоор л бөөлжмөөр санагддаг таагүй байдаг тухай өгүүлж байна. Солонгос хэлэнд “бөөлжис хүрэх” санааг 멀미가 나다 [молмига нада] буюу бөөлжис гарах гэж илэрхийлдэг.

Цаашлаад үйл үгийн энэ сэтгэл хөдлөлийн өнгө аястай “**дургүй хүрэх**” (싫증이 나다[шилжыни нада]) нь сэтгэлд тааламжгүй санагдах гэсэн утгыг хүрэх үйл үгээр илэрхийлдэг. Жишээлбэл “*Зөвхөн өөрт нь сургуулийн махнаас ашиг олъё гэхэд нь саад хийсэн Бат унаж байгаад дургүй нь хүрч байлаа.*” (ТТ IV:5) гэсэн байна. Харин солонгос хэлэнд дургүй хүрэх утгыг 싫증이 나다 [шилжыни нада] буюу 싫증 [шилжин] жигшил, дургүйцэл гэсэн утгатай үг бол 나다 [нада] гарах, ургах гэсэн утгатай үйл үг юм.

<sup>4</sup> Ч. Лодойдамба “Тунгалаг тамир” роман.



“зэвүү хүрэх” (혐오하는 마음이 생기다[хёмуханын маыми сэнгида]) гэдэг нь хийсэн үйлдсэн зүйл болон гаргаж буй зан авирт нь эвгүйцэн жигших гэсэн утгатай. Жишээлбэл “Тэгэхэд нь Цогзолын зэвүү хүрч түүнийг майхны амаар чулуудсан мэт санагдавч тэсэж өнгөрөөдөг байлаа.” (МУЗД:155) Харин солонгос хэлэнд 혐오하는 마음이 생기다 [хёмуханын маыми сэнгида] гэж хэлдэг бөгөөд энэ нь 혐오하다 [хёмухада] дургүй хүрч үзэн ядах, 마음 [маым] сэтгэл, 생기다 [сэнгида] төрөх бий болох гэсэн утгатай үгсээс бүтдэг байна. Эндээс харахад монгол хэлэнд “зэвүү хүрэх” гэдэг бол солонгос хэлэнд “бий болох” гэдэг үйл үгээр илэрхийлдгээрээ ялгаатай байна.

“уур хүрэх” (화가 나다[хуага нада]) нь хилэн, ихэд дургүйцэж хорсох байдал, дотор давчдан бухимдах мэдрэмж төрөхийг хэлнэ. Жишээ нь “Дамдинг өөрөөсөө айгаад байна гэдгийг мэдсэн мэт улам ч хойрго сажлахад нь уур хүрч цухалдна.” (МУЗД:229) гэжээ. Харин “уур хүрэх” гэдгийг солонгос хэлнээ 화가 나다 [хуага нада] гэх ба 화[хуа] гэдэг нь уур бухимдлыг илэрхийлсэн үг, нада [нада] гарах гэсэн утгатай үгсээс бүрдээд үгчлэн орчуулбал “уур гарах” гэж илэрхийлдэг байна.

“хөх инээд хүрэх” (비웃음이 나다[биүсыми нада]) гэдэг нь зэвүүрхэн хүйтнээр инээхэд хүрэх, дургүйцэн хорссон байдал гаргах, мөн зэвүүцэх, басамжлах, тавлах, тохуурхах зэрэг утгатай. Жишээлбэл “Хамар Жамба “Уул” нэгдлийнхэн Жамъянг бригадын дарга болголоо гэдгийг дуулаад хөх инээд нь хүрч, би хэрвээ тэр нэгдэлд нь орсон бол бүр том дарга ч болох байгаа вий гэж өгүүлэх дөхжээ.” (МУЗД:188) гэснээс харвал Жамбаа Жамъянг дарга болсонд нь дургүйцэж байгааг илэрхийлж байна. Солонгос хэлнээ энэ санааг 비웃음이 나다 [биүсыми нада] гэж хэлдэг бгггд ггний г солонгос хэлний их тай лбар толиндсандагдлыг 알보거나 놀리거나 흉을 보듯이 웃는 일.[сандэрыл ятбугона нуллигона хюныл будыши үнын ил] Бусдыг басамжлан шоолох буюу гоочлох мэтээр инээх явдал хэмээн тайлбарласан. 비웃음 [биүсым] гэдэг нь шоолж инээх, нада [нада] гарах гэсэн утгатай үгс болно. Монгол хэлэнд “хөх инээд хүрэх” гэдгийг солонгос хэлэнд “шоолж инээд гарах” гэж илэрхийлдгээрээ ялгаатай байна

“залхуу хүрэх” (싫증이 나다, 게으르다[гвэга нада, гэирыда]) гэдэг нь ямар нэг үйл хийх хүсэл төрөхгүй байх, бие нозоорон ядарч, амармаар болохыг хэлдэг. Жишээлбэл “Энэ бол эцгийн минь үед хураасан торго, энэ бол би Бээжингээс авчирсан чирчүү, яг л шир шиг, энэ бол хивс» гэх зэргээр ярьж байгаа тайжийг шоолж яваа Итгэлтийн залхуу нь хүрч хааяа хааяа эвиээн байхыг нь хараад «мань Итгэлт ч аргагүй л юм үзсэн хүн юм даа» гэж Эрдэнэ бодов.” (ТТИ:82) хэмээн Итгэлтийн хүсэл төрөхгүй ядарч байгааг илэрхийлсэн байна. Солонгос хэлнээ энэ үгийг 싫증이 나다 [шилжини нада] мөн 게으르다 [гэирыда] гэж хэлдэг. 싫증이 나다 [шилжини нада] нь 싫증 [шилжин] дургүйцэл, жигшил гэсэн утгатай бол нада [нада] гарах гэсэн үг болно. Ажил хийхгүй байх арга, заль гаргах гэсэн үг юм. Харин 게으르다 [гэирыда] нь залхуурах гэсэн үйл үг. 게으른 사람이 성공하는 것 봤어? Залхуу хүн амжилтанд хүрэхийг харсан уу?

“эгдүү хүрэх” (혐오하다[хёмухада]) гэдэг нь дур таалалд үл нийцэх зүйлийг жигших голох, сочиж зэвүүрхэх сэтгэгдэл төрөх (МХТТТ) Жишээлбэл “Дамдин

*эгдүү нь хүрсэн, эсвэл хүзүү рүү нь хүйтэн юм дусаасан адил хүзүүгээ нугдайлан амаа ангайн хэлээ булталзуулан машинаа залж явав.” (МУЗД:466) Солонгос хэлний 힘 오하다 [хёмухада] дургүй хүрч үзэн ядах гэсэн үгтэй утга дүйнэ.*

## **2) Эерэг үнэлэмж илэрхийлсэн үгс**

Хүний сэтгэлд таатай, сайхан мэдрэмж төрүүлэх нь эерэг үнэлэмж юм. Үүнд “Хорхой хүрэх” (탐나다), “Хөх инээд хүрэх” (비웃음이 나다), “инээд хүрэх” (웃음이 나다), “Хайр хүрэх” (사랑스럽다), “Дур хүрэх” (욕망이 생기다), “Зүрхэнд хүрэх” (마음에 와 닿다) зэрэг үгс багтана.

“**хорхой хүрэх**” (탐나다[тамнада]) гэдэг нь ихэд шимтэн хүсэх, ямар нэгэн юманд шунаж дурлах гэсэн утгатай (МХИТТ). Үүнийг жишээнээс харвал “Эл дөрвөн захын нэг, сүүн зах дээр айраг таргийн исгэлэн сайхан үнэр, сүү саалийн хорхой хүрмээр зөөлөн үнэр, идэшний элдэв ногоо, давсалсан шанцай, хуурсан самар сэлтийн үнэр холилдон ханхална.” (МУЗД:96) гэж хичнээн амттай, идэхийг хүсэж буйгаа илэрхийлсэн байна.

Харин солонгос хэлэнд энэ санааг 탐나다 [тамнада] гэх үгээр илэрхийлдэг байна. Энэ нь 탐 [там] гэдгийг тайлбар толиндгазигерна 차지하고 싶은 마음 (СХСИТ) Өөрийн болгох, эзэгнэхийг хүссэн сэтгэлийг илэрхийлдэг. Харин 나다 [нада] мөн л гарах гэсэн үг юм. Ингээд нэгтгээд үзвэл монгол хэлэнд “хорхой хүрэх” гэж хэлдэг бол солонгос хэлэнд “хүсэл гарах” гэж хэлдэг байна.

“**инээд хүрэх**” (웃음이 나다 [үсыми нада]) инээд дэврэн хөдлөх гэсэн утгатай (МХИТТ). Иймээс “инээд хөдөлдөг” бөгөөд наашлах буюу ойртох гэсэн утгыг илтгэж байгаа нь “-руу, рүү” буюу чиглэл заасан үг авахгүйгээр шууд үйл үгээр илэрхийлж байгаагийн баримт юм. Харин “Юндэнгийн хөх инээд хүрч, эхнэр рүү хараад «Итгэлт ч олон газар явсан хүн юм аа» гэлээ.” (ТТ1:95) гэсэн нь “дургүйлхэн хорссон (МХИТТ) гэсэн утга бөгөөд Юндэн Итгэлтийн талаар зэвүүрхэн буйг өгүүлсэн байна. Харин солонгос хэлэнд 웃음이 나다 [үсыми нада] буюу инээд гарах гэж хэлдэг.

“**хайр хүрэх**” (사랑스럽다 [сарансыробда]) гэдгийг дотнолох сэтгэл эрхгүй төрөх өөрөөр бол хайрлах хүсэл төрөх гэж тайлбарлаж болно. Өөрөөр хэлбэл, ойр дотно сайхан мэдрэмж бий болох, өөрт мэдрэгдэхээс оюуншиж үүссэн үг юм. Жишээнээс харвал, “Ярилцлага хийх цаг хүрэхгүй хугацаанд ингээж буужигнаж, шаагилдаж байгаа юм чинь гэртээ хэрхэн олуулаа шуугилдаж, хөгжилдөн, уйлж, дуулж байдаг бол гэж төсөөлөхөд ч хайр хүрэм.” (eguiir.mn/301993/) гэсэн нь богино хугацаанд хүүхдүүдийг нь харсан ч гэртээ хэчнээн хайр татам байдаг бол хэмээн төсөөлж бичсэн байна.

Харин солонгос хэлэнд энэ санааг 사랑스럽다 [сарансыробда] гэж хэлдэг бөгөөд энэ 사랑[саран] хайр + 스럽다 [сыробда] тийм шинж агуулсан гэсэн утгыг нэмж, тэмдэг нэр үүсгэдэг дагавар залгасан байна. Тэгэхээр монгол хэлний “хайр хүрэм” хэмээх үгийг солонгос хэлнээ дагаврын аргаар бүтсэн тэмдэг нэрээр буюу “스럽다 [сыробда]” гэсэн үгээр илэрхийлж байгаа нь бүтцийн үүднээс ялгаатай байна.

“**дур хүрэх**” (욕망이 생기다[югманы сэнгида]) нь аливаа юмыг бахдах, шохоорхон хүсэх гэсэн утга илэрхийлсэн. Жишээлбэл, “Муу дур нь хүрвэл, тахиж байгаа бурхнаа босоо ороолон болгодог, сайн дураа хөдөлбөд хүн алсан

яргачныг бурхан болгодог башир аргыг мэднэ.”(ТТІ:6) гэсэн нь хүссэнээрээ өөрчилдөг гэсэн санаа илэрхийлж байна.

Харин солонгос хэлэнд уг санааг 욱망이 생기다 [югманы сэнгида] буюу 욱망 [югман] хүсэл шунал 생기다 [сэнгида] бий болох гэсэн үгээр илэрхийлдэг.

“**зүрхэнд хүрэх**” (마음에 와 닿다 [маымэ уададда]) сэтгэл зүрхийг догдолтол гайхшируулж, баярлуулах мэдрэмж төрөхийг илэрхийлсэн утгатай. Жишээлбэл “*Франц үзэгчдийн зүрхэнд хүрсэн Монгол циркчид Европоор аялан тоглох 5 жилийн гэрээ байгуулжээ.*” ([gogo.mn/r/41eqk](http://gogo.mn/r/41eqk))

Солонгос хэлэнд 마음에 와 닿다 [маымэ уададда] гэсэн үгтэй утга дүйнэ. Энэ нь 마음에 [маымэ] сэтгэлд, 와 닿다 [уададда] тулж, ирж хүрэх гэсэн утгатай. Ингэхлээр “зүрхэнд хүрэх”-ийн үйл үг хүрэх гэдэг нь энэ үгийн хувьд хоёр хэлэнд адилхан “хүрэх” гэсэн үгээр бичиж хэрэглэдэг байна.

Сэтгэл хөдлөл илэрхийлсэн уг айд монгол хэлнээ “хүрэх” үйл үгээр илэрхийлдэг бол солонгос хэлнээ нада [нада] “гарах” мөн 생기다 [сэнгида] бий болох гэсэн үйл үгээр илэрхийлдгээрээ ялгаатай харагдаж байна.

#### **б. Мэдрэмж ойртох утга илтгэсэн**

Энэ хэсэгт хүний биед болж буй биологийн хүчин зүйлсийг илэрхийлэхдээ “хүрэх” гэдэг үгтэй нийлэмж үгээр илэрхийлж байна. Тухайлбал, хүний өтгөн шингэн ялгарахыг завдах бол “баас хүрэх”, “шээс хүрэх” гэнэ. Цаашилбал, “бөөлжис хүрэх”, “нойр хүрэх”, “гигиг хүрэх” гэх зэргээр илэрхийлнэ.

“**Бөөлжис хүрэх**” (멀미가나다 [молмига нада]) нь бөөлжмөөр санагдах, дотор муухайрах утга илтгэсэн үг. Жишээлбэл “*Зарим эмийн гаж нөлөөнөөс шалтгаалсан бөөлжис хүрэх, бөөлжих, жирэмсний бөөлжилт болон мигрений шалтгаант огиулалтад хэрэглэнэ.*” ([www.monfatrade.mn](http://www.monfatrade.mn)) Тус үгийг солонгос хэлнээ 멀미가나다 [молмига нада] гэх бөгөөд 멀미 [молмига] дотор муухайрах, бөөлжис цутгах гэсэн утгатай бол нада [нада] “гарах” гэсэн утгатай үйл үг юм. Үүнийг жишээнээс харвал 배에 타자마자 멀미가났다. [бэ-э тажамажа молмига надда] Завинд суумагц дотор муухайрч бөөлжис хүрэв,

“**Нойр хүрэх**” (잠이오다 [чами уда]) нь өөрийн эрхгүй унтмаар болох (МХИТТ). Жишээ нь “*Гэвч тэдний нойр нэг л сайн хүрэхгүй хөрвөөсөөр байв.*” (МУЗД:357) гэсэн нь унтах мэдрэмж төрөхгүй байгаа гэсэн үг. Харин энэ санааг солонгос хэлнээ 잠이오다 [чами уда] гэж хэлдэг бөгөөд 잠 [чам] гэдэг нь нойр гэсэн үг бол 오다 [уда] нь ирэх гэсэн үйл үг юм. Монгол хэлэнд “нойр хүрэх” гэж ярьдаг бол солонгос хэлэнд “нойр ирэх” гэж хэлдэг байна.

“**Шээс хүрэх**” (오줌이마렵다 [ужүми марёбда]) нь шээс гоожиж гарах гэж байгаа мэдрэмж төрөхийг хэлнэ. Жишээлбэл “*Түгээмэл илэрдэг шинжүүдэд : Ойр ойрхон шээс хүрэх, шээх үед хорсох, шархирч өвдөх, дутуу шээсэн мэт санагдах, шээс үнэртэй гарах нь элбэг.*” (<http://ikon.mn/n/24ya>)

Солонгос хэлэнд шээс хүрэхийг 오줌이마렵다 [ужүми марёбда] гэж хэлдэг. 오줌 [ужүм] шээс, 마렵다 [марёбда] хүрэх гэсэн үг бөгөөд уг үгийг зөвхөн шээс, баас хүрэх гэдэгт л хэрэглэдэг онцлогтой.

“**Гигиг хүрэх**” (간지러움을타다 [ганжироүмыл тада]) гэдэг нь гигиг хөдлөх гэсэн утгатай үг юм. Жишээлбэл “*Аятайхан согоо байна шүү, дамшиг чинь гээд Итгэлт жоготой бөгөөд гигиг нь хүрсэн бололтой инээв.*” (ТТІ:91)

Харин солонгос хэлнээ гижиг хүрэхийг 간지러움을 타다 [ганжироумыл тада] гэж хэлдэг бөгөөд хүрэх гэдгийг 타다 [тада] буюу унах, суух гэсэн утгатай үйл үгээр илэрхийлдэг.

#### **в. Хэмжээнд хүрэх утга илтгэсэн**

Энэ үйл үгээр тухайн хэмжээ, загварт дөхсөн гэсэн утга илтгэсэн нийлэмж үгс багтана. **“Насанд хүрэх”** (어른이 되다[орыни дуэйда]) *“Чингэсээр, нэгэнт насанд хүрсэн ач охиноо эрд өгөх чухал цаг тулгарч ирэв”* (*“Чингис Хаан” В. ЯН 1950:388*)

**“Хоёр нас хүрэх”** (두 살이 되다[дү сари дуэйда]) хоёр настай болох гэсэн утгатай. Жишээ нь *“Дулмаа эхнэр болсноос хойш Төмөрийн гэрт ертөнцийн хоёрдугаар нар мандаж хүү гарсанд Бадрах гэж нэр өгсөн нь одоо хоёр нас хүрч байгаа ажээ.”* (ТТІ:104)

Солонгос хэлэнд нас ахих хүрэх гэдгийг 되다 [дуэйда] болох гэдэг үгээр илэрхийлдэг. Жишээлбэл *우리 아이가 두 살이 되었다.*[үри айга дү сари дуэ одда] Манай хүүхэд хоёр нас хүрлээ.

**“Хэмжээнд хүрэх”** (도달하다[дудархада]) ямар нэг хэмжээнд очих, тулах гэсэн утга илтгэсэн. Жишээлбэл *“Чингэснээр цаатан ардын аж байдал соёлын түвшин нь дээшилж, зэргэлдээх бусад ястны адил хэмжээнд хүрчээ”* (Х. Нямбуу, 2012:244) Харин Солонгос хэлэнд уг санааг 도달하다 [дудархада] гэж хэлдэг бөгөөд энэ нь **목적인 곳이나 수준에 다다르다**. [мугжогхан гушина сүжүнэ дадарыда] Хүссэн газар юм уу хүссэн хэмжээнд хүрэхийг хэлнэ гэж СХСИТ-д тэмдэглэсэн байна. Тэгэхээр **“хэмжээнд хүрэх”** гэдэг үгийг хоёр хэлэнд адил сэтгэж илэрхийлсэн болохыг харж байна.

Харин **“Эрийн цээнд хүрэх”** (남자가 되다, 장성하다 [намжага дуэйда, жансонхада]) нь нас бие гүйцэж бяра чадал суухыг хэлж байгаа боловч **“эр хүний хэмжээнд хүрэх”** гэсэн хэмжүүрийн утга илтгэнэ. Жишээлбэл *“Эрийн цээнд хүрсэн ч эцгийн сургаалыг марталгүй явах сайхан.”* (МСИТ)

Солонгос хэлэнд **“эрийн цээнд хүрэх”** гэсэн санааг 장성하다 [жансонхада] гэж хэлдэг бөгөөд энэ нь 長 том хүн 장 [жан], 成 хүрэх, биелүүлэх 성 [сон] (СХСИТ) гэсэн хоёр ханз үгнээс бүрдсэн өсөж том болж насанд хүрсэн гэсэн утгатай.

**“Үнэд хүрэх”** (비싸지다[биссажида]) гэдэг нь худалдах гэсэн юмны үнэ их болохыг илтгэсэн үг. Жишээлбэл *“Өнөөдөр /2024.11.13/ байдлаар авто машины хотын дугаар цифрээсээ хамаарч 500 мянгаас хоёр сая төгрөгийн үнэд хүрчээ.”* (<https://news.mn/r/2763340/>) их үнэтэй болсон гэсэн санааг хүрэх үйл үгээр илэрхийлсэн байна. Харин солонгос хэлэнд энэ санааг 가격이 오르다 [гагёги урыда], 비싸지다 [биссажида] гэж хэлдэг. Эдгээр нь 비싸지다 [биссажида] үнэтэй болох гэсэн үг бол 가격 [гагёг] үнэ, 오르다 [урыда] өсөх буюу үнэ өсөх гэсэн үг юм.

**“Үгэндээ хүрэх”** (약속을 지키다 [ягсугыл жикида]) нь хэлсэн, амласандаа хүрэх, хэлсэн үгээ ажил болгох гэсэн утгатай. Жишээлбэл *“Тэр хэлсэн үгэндээ хүрсэн.”* (<https://amlalt.mn/p/1002644>) гэж Л. Оюун-Эрдэнэ сайдын талаар нэгэн сонинд нийтэлсэн байна. Энэ нь хэлснээ хийж гүйцэтгэсэн гэсэн утгатай.

Харин солонгос хэлэнд 약속을 지키다 [ягсугыл жикида] буюу амлалтаа биелүүлэх гэсэн үгээр илэрхийлдэг байна.



“Санасандаа хүрэх” (생각을 이루다[сэнгагыл ирүда]) гэдэг нь зорьсондоо хүрэх, зорилгоо биелүүлэх гэсэн утгатай. “Хэдийгээр Л. Гантөмөр санасандаа хүрсэн ч сэтгэл дундуур үлдсэн бололтой.”(<https://gogo.mn/r/16940>) санасан зүйлээ хийсэн ч сэтгэл дундуур үлдсэн хэмээн өгүүлжээ. Солонгос хэлэнд үүнийг 생각을 이루다 [сэнгагыл ирүда] гэж илэрхийлдэг бөгөөд үүний 생각 [сэнгаг] бодол, санаа, 이루다 [ирүда] нь биелүүлэх гэсэн үг юм.

#### **г. Мэдэгдэх, сонсогдох утга илтгэсэн**

“Хүрэх” үйл үгийн хийсвэр утгын нэг төрөл бол бие бодтой биш хэл, мэдээ, сураг занги зэргийг сонсгох бол “хэл хүргэ” хэмээн эртнээс хэлж заншсан бөгөөд энэ нь мэдээ дуулга, сонсго гэсэн утга илтгэнэ.

“Сонорт хүрэх” (귀에 닿다 [гвүйэ тадда]) гэдэг нь хүмүүсийн хэлсэн, ярьсан зүйл тухай дуулах, мэдээ авахыг хэлдэг. Жишээ нь “Дарлагдлын гинжинд яснаасаа жигшсэн ард түмэн байна. Бас ойрын өдөр нэг баримт бичиг дэлхий дахины сонорт хүрнэ.” (ТТIII:62)

Солонгос хэлэнд уг санааг чихэнд хүрэх буюу 귀에 닿다 [гвүйэ тадда] гэж хэлдэг нь хоёр хэлэнд адил “хүрэх” үйл үгээр илэрхийлдэг байна.

“Хэл мэдээ хүрэх” (소식을 전달하다 [сушигыл жондархада]) буюу хэл дуулгах гэсэн үг. Жишээ нь “Ингээж инээлдэн явтал өмнөөс нь морьтой монгол хүн давхин ирж гамингууд ард олныг дээрэмдэн, тэдний өвсийг хураан авч байгаа тухай мэдээ хүргээж ирлээ.” (ТТI:62) энэ нь тухайн мэдээг нэг газраас нөгөөд хүргэж байгаа учир монгол хэлэнд “хүргэх” үйл үгээр илэрхийлдэг бол солонгос хэлэнд дамжуулж байгаагаар сэтгэж мэдээ дамжуулах 소식을 전달하다 [сушигыл жондархада] гэж хэлдэг байна. Энэ нь 소식 [сушиг] мэдээ, сураг мэтийг 전달하다 [жондархада] дамжуулах гэх үйл үгээр илэрхийлдэг байна.

“Сэтгэлд хүрэх” (마음에 들다 [маймэ дылда]) нь санаад нийцэх гэсэн утгатай үг. Жишээлбэл “Н. Алтанхуяг журмын нөхдийнхөө сэтгэлд хүрсэнгүй” ([gogo.mn/r/kko4w](https://gogo.mn/r/kko4w)) энд сэтгэлд хүрээгүй гэж эсрэг утгаар нь жишээ татсан. Харин солонгос хэлэнд 마음에 들다 [маймэ дылда] буюу сэтгэлд нийцэх гэсэн үгтэй дүйнэ. Монгол хэлэнд хүрэх үйл үгээр илэрч байгаа бол солонгос хэлэнд нийцэх үйл үгээр илэрхийлдэг байна.

#### **д. Үр дүн илэрхийлсэн**

Тухайн зүйл бий болсныг илтгэх нь “хүрэх”-тэй нийлэмж үгээр илэрнэ. Энэ нь тухайн зүйлийн үр дүнг заасан утга илтгэнэ. Ханиадаар өвчилсөн бол ханиад хүрэх, хор хөнөөлтэй зүйл мэдрэгдвэл “хор хүрэх” гэх мэтээр нэрлэлт үүсгэжээ.


Аливаа зүйл өвчин тахал, хараал зэрэг ирснийг илтгэнэ. “Өвчин хүрэх” (병에 걸리다 [бёнэ голлида]) өвчин тусч бие зовуурь шаналгаатай болохыг хэлнэ. Солонгос хэлэнд өвчин хүрэх, өвчин тусахыг 병에 걸리다 [бёнэ голлида] гэж хэлдэг. Энэ нь 병 [бён] өвчин 걸리다 [голлида] тээглэх гэсэн утгатай үйл үг. Монгол хэлэнд “өвчин хүрэх” гэдгийг солонгос хэлнээ “өвчинд тээглэх” гэж илэрхийлдэг байна. Мөн “ханиад хүрэх” гэж монгол хэлэнд ярьж дадсан байдаг. Үүнийг солонгос хэлэнд мөн адил 감기에 걸리다 [гамгиэ голлида] хэмээн ханиаданд тээглэх гэсэн үйл үгээр илэрхийлдэг онцлогтой. Жишээ нь 그는 감기에 걸려 공연을 취소하기로 했다. [гынын гамгиэ голлэ гунёныл чүйсухагиру хэддэ] Тэрээр ханиад хүрээд тоглолтоо цуцлахаар шийджээ.

“Хараал хүрэх” (저주하다 [жожүхада]) нь бусдын хараасны дагуу муу зүйл тохиолдох явдлыг хэлнэ. “Хиллари Клинтон Америкийн Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдал хүлээх болсон шалтгаан нь түүнд “Үхэгийн гүнж” нэрээрээ алдаршсан Сибирийн занданшуулсан шарилын “хараал хүрсэн” хэмээн бичжээ.” (gogo.mn/r/203717?i)

Солонгос хэлний 저주하다 [жожүхада] гэдэг үгтэй утга дүйнэ. Энэ нь 남에게 재앙이나 불행이 일어나도록 빌고 바라다. Хэн нэгэнд гамшиг, золгүй явдал тохиолдохыг хүсэх гэсэн утгатай.(СХСИТ)

“Хор хүрэх” (훼방하다 [хвэбанхада]) нь хөнөөл болох гэсэн утгатай. Солонгос хэлний 훼방하다 [хүэбанхада] гэх үгтэй утга дүйнэ. Жишээлбэл 우리가 할 수 있는 일은, 놈들의 일을 방해하고 훼방하는 것뿐이야. Бидний хийж чадах зүйл бол тэдний ажлыг үймүүлж, тасалдуулах явдал юм.(СХСИТ)

Дээрх ангиллыг дараах байдлаар нэгтгэн харуулав.



Зураг 2. Монгол хэлний “хүрэх” үйл үгийн утгын ангилал

Солонгос хэлний “당다[датта]/хүрэх” үйл үгийн шилжмэл утгын судалгаа: Аливаа хэлний үгийн утга нь хүн юмсыг танин мэдэхүйн үйл явцаар бий болдог. Бид өмнө хэсэгт монгол хэлний “хүрэх” үйл үгийн шилжмэл утгыг авч үзсэн бол энэ хэсэгт солонгос хэлний “당다[датта]/хүрэх” үйл үгийн цөм утга ба шилжсэн утга хэрхэн үүссэн, хэрхэн хийсвэрлэн утга үүсгэж байгааг хэлний жишээ баримтаар судлан үзэв. Үүний тулд эхлээд солонгос хэлний “당다[датта]/хүрэх” үйл үгийн утгыг 표준국어대사전 (СХСИТ) (국립국어연구원, 1999), 고려대한국어대사전 [гурёдёхангүгосажон], 우리말샘

[үрималсэм] зэрэг толь бичгийн тайлбарыг судлан үзэхэд а. нэг объект өөр биеттэй холбогдох. б. тодорхой газар хүрэх. в. мэдээ мэдээлэл гэх мэтийг хүргэх гэсэн ерөнхий гурван утгаас нарийвчилсан наймаас есөн утгыг тайлбарласныг нэгтгэн үзвэл. 1. Хүрэх утга илэрхийлсэн. 2. Хүрэх, очих утга илэрхийлсэн. 3. Нөлөө ба хүрээлэл ямар нэгэн газар болон зүйлд хүрэх гэсэн утга илэрхийлсэн. 4. Хүч чадал, чадвар зэрэг нөлөөлөх утга илэрхийлсэн. 5. Олдох, таарах утга илэрхийлсэн. 6. Нийцэх, дүйх гэсэн утга илэрхийлсэн. 7. Буух, ойлгогдох утга илэрхийлсэн. 8. Холбогдох гэсэн нийт найман утга илэрхийлдэг(СХСИТ) хэмээн тодорхойлсон байна.

Дээрх утгын ангиллыг нэгтгэн үзвэл үндсэн утгаас гадна хүрэх очих, мэдээ дамжуулах, нөлөөлөх, боломж аз таарах, таарах тохирох, холбоо хамааралтай гэсэн утгыг илтгэдэг болох нь тодорхой байна.

Харин “달다 [датта]/хүрэх” үйл үг орсон хэлц үгийг (박영준, 최경봉 “관용어사전”, 태학사, 1997) түүвэрлэн үзвэл 길 이 달다 [гири датта], 동 이 달다 [дуни датта] (1, 2), 등 이 달다 [дыни датта], 선 이 달다 [сони датта], 손 이 달다 [суни датта], 맥 이 달다 [мэги датта], 줄 이 달다 [жүри датта], 손길 이 달다 [сунгири датта], 손 이 달다 [суни датта] (1, 2), 입 에 달다 [ибэ датта], 코 가 땅 에 달다 [куга данэ датта], 피부 에 와 달다 [пибү-э ва датта], 가슴 에 달다 [касымэ датта], 가슴 에 와 달다 [касымэ ва датта], 숨 이 턱 에 달다 [сүми тогэ датта], 이마 에 와 달다 [има-э ва датта] гэсэн үгс нь солонгос хэлний “달다/Хүрэх”-ийн шилжсэн утга нь аливаа юм ойртох, тулж ирэх гэсэн утгаас оюуншуулан хийсвэрлэж олон утга үүсгэжээ. (박영준 외, 1997).

Солонгос хэлний “달다/Хүрэх”-тэй нийлэмж үгсийг дараах байдлаар ангилан үзлээ.

#### **а. Чиглэл заасан утга илтгэсэн**

Танин мэдэхүйн хэл шинжлэлд зүг чигийг тодорхойлохдоо чиглэл заасан бүдүүвч (orientational schema)-ээр авч үздэг бөгөөд босоо чиглэлийг “дээр–доор”-оор, хөндлөн чиглэлийг “урд – ард” бүдүүвчээр тус тус авч үздэг юм. Энэ бүдүүвч нь бидний биеийн бүтэц болон туршлагад тулгуурлан бий болсон бөгөөд үнэт зүйлсийн тухай гүн ухааны сургаалын (axiology) шинж чанарыг агуулдаг. Krzeszowski (1993) бичихдээ “туршлагад суурилсан дүрийн бүдүүвч нь “ээрэг” ба “сөрөг”-ийн эсрэгцлээр улам идэвхэждэг” гэжээ (임지룡, 1995).

Солонгос хэлний 길 이 달다 [гири датта] –г үгчилбэл зам нь хүрэх гэсэн үг болно. Харин шилжсэн хийсвэрлэсэн утгаар бол харилцаа холбоо тогтоох гэсэн утгатай.

“다행스럽게도 돈 많은 사람에게 길이 닿아 일이 순조롭게 풀리고 있습니다.” Аз болж мөнгөтэй хүнтэй холбоо тогтоогоод ажил бүтэмжтэй байна. (СХСИТ)<sup>5</sup>

동 이 달다 [дуни датта] энэ нь хоёр утгатай бөгөөд ① Тасралтгүй үргэлжлэх гэсэн утгатай. Жишээлбэл “자재와 인력이 부족해 일의 동이 닿기가 쉽지는 않을 것입니다. (СХСИТ)” Түүхий эд, хүн хүч дутмаг учраас тасалдуулалгүй ажиллуулах амаргүй байх болно.

<sup>5</sup> Солонгос жишээ өгүүлбэрийг солонгос хэлний стандарт их толь бичгээс (СХСИТ) авав. <https://stdict.korean.go.kr/main/main.do>

Дараагийн утга нь ② уялдаатай, авцалдаатай гэсэн утга бий. Жишээ нь “학생 하나가 전혀 동이 닿지 않는 말을 한참 하다가 돌아갔다. (СХСИТ)” Нэг оюутан хэсэг ямар ч утгагүй юм ярьж байснаа эргээд явчихав гэсэн нь ойлгомжгүй юм ярьсан тухай өгүүлж байна.

선이 닿다 [сони датта] үгчилбэл зураас, шугам хүрэх гэсэн үг болох бөгөөд энэ нь утга шилжиж холбоо харилцаатай гэсэн утга үүссэн байна. Үүнийг жишээнээс харвал “김의원은 여당에서 유일하게 재야와 선이 닿아 있는 사람이었다. (СХСИТ)” Эрх баригч намаас сөрөг хүчинтэй ойр дотно харилцаатай байсан цорын ганц хүн бол Ким гишүүн байв.

손이 닿다 [суни датта] үгчилбэл гар хүрэх гэсэн үг. Харин шилжсэн утга нь ① Хүчтэй байх, хүчлэх гэсэн утгатай. Жишээлбэл “내가 손 닿는 데까지 힘써 볼 테니 너무 근심 말아요. (СХСИТ)” Би хөлөө хүрэх газраар явж чадах бүхнээ хийх болно, тиймээс битгий их санаа зов.

맥이 닿다 [мэги датта] үгчилбэл холбоо хүрэх гэсэн үг болно. Харин шилжсэн утгаараа холбогдох гэсэн утгатай. Жишээ нь “고위층에 맥이 닿는다고 큰소리 칠 때는 언제고, 이제 와서 오리발 내미는 것은 또 무슨 심보입니까? (СХСИТ)” Өндөр албан тушаалтнуудтай холбоо тогтоосон гээд том дугараад байсан нь хэзээ билээ, одоо болохоор юу ч болоогүй юм шиг байгаа чинь ямар учир вэ?

줄이 닿다 [жүри датта] 줄 [жүл] гэдэг нь уяа, утас, оосор гэсэн үг бөгөөд утга шилжин тусалж чадах хүнтэй холбогдох холбоо тогтоох гэсэн утга үүсгэсэн байна. Жишээлбэл “어디 군청에 줄 닿을 만한 사람 없는지 알아 봐. (СХСИТ)” Тус мужийн албанд холбогдох хүн байгаа эсэхийг олж мэдээрэй. Энэ хэсэгт “хүрэх” үйл үгийг оюуншуулж хоёр зүйлийг холбох, холбогдох утга гэсэн үүссэн болох нь жишээнээс харагдаж байна.

#### **б. Орон зай илтгэсэн**

Солонгос хэлний 손길이 닿다 [сунгири датта] -г үгчилбэл урт гар хүрэх гэсэн үг бөгөөд монгол хэлнээ урт гартай буюу хүрэхгүй газар үгүй гэсэн утгатай дүйнэ. Жишээлбэл “그 사람 손길이 닿지 않은 곳이 없다. (СХСИТ)” Тэр хүний гар хүрэхгүй газар гэж үгүй. Энэ жишээнээс харвал монгол солонгос хэлэнд хүрэхгүй чадахгүй газар үгүй гэдэг санааг адилхан урт гар гэсэн үгээр илэрхийлдэг боловч солонгос хэлэнд хүрэх гэдэг үйл үг заавал ордоогоороо ялгаатай байна.

손이 닿다 [суни датта] үгчилбэл гар хүрэх гэсэн үг. Харин шилжсэн утга нь ② Тодорхой хэмжээ хүрээнд хүрэх гэсэн утгатай. Жишээнээс харвал “일흔 고개에 손이 닿은 아버지지만 아직도 정정하시기는 이십 년 전과 같다. (СХСИТ)” Дал хүрч яваа аав маань одоо болтол хорин жилийн өмнөх шигээ хөнгөн шингэн.

코가 땅에 닿다 [куга данэ датта] энэ нь шууд утгаараа хамар нь газар хүрэх гэсэн үг бөгөөд шилжсэн утга нь толгой бөхийлгөх гэсэн утга илтгэнэ. “코가 땅에 닿도록 빌었건만 아무 응답이 없다. (СХСИТ)” Би сөгдөн мөргөж гуйсан боловч ямар ч хариу алга.



피부에 와 닿다 [пибү-э ва датта] энэ нь арьсаараа хүрч мэдрэх гэсэн утгатай үг бөгөөд шилжсэн утга нь өөрийн биеэр туулах, мэдрэх гэсэн утга үүссэн байна “선생님의 말씀은 언제나 피부에 닿다. (СХСИТ)” Багшийн хэлсэн үгийг үргэлж яс махандаа тултал мэдэрдэг.

등이 닿다 [дыни датта] үгчилбэл нуруу хүрэх гэсэн үг болох боловч уг утга нь том танил талдаа найдах, ардаа найдах гэсэн утгатай. Жишээлбэл “나 혼자서 한 일이 아니라 권력층과 등이 닿아 했던 일입니다. (СХСИТ)” Энэ бол миний ганцаараа хийсэн зүйл биш, эрх мэдэлтэй найдвартай хүмүүстэй хамтарч хийсэн зүйл.

Энэ хэсэгт “хүрэх” үйл үгээр хүрэхгүй, чадахгүй зүйл байхгүй, ямар нэг хэмжээнд хүрэх, хүлцэнгүй даруухнаар гуйх, өөрийн биеэр мэдрэх, найдах гэсэн шилжсэн утга үүсгэсэн байна.

#### **в. Хийсвэр утга илтгэсэн**

Энэ 가슴에 닿다 [касымэ датта] гэдэг нь сэтгэлд хүрэх буюу сэтгэл хөдлөх гэсэн утгатай.

“선생님의 고별사 중 가장 가슴에 닿았던 것은 우리를 가르치면서 사랑이라는 것을 알았다는 말이었다. (СХСИТ)” Багшийн үдэлтийн үеэр хэлсэн үгээс миний сэтгэлийг хамгийн ихээр хөдөлгөсөн зүйл бол бидэнд хичээл заадаг байхдаа хайр гэж юу болохыг ойлгож авсан явдал гэж хэлж байсан үг юм.

가슴에 와 닿다 [касымэ ва датта] Мөн адил сэтгэл хөдлөх гэсэн утга илтгэдэг. Жишээлбэл “슬쩍 가슴에 와 닿는 그녀의 미소. (СХСИТ)” Түүний инээмсэглэлд миний сэтгэл хөдлөв.


Энэ хоёр жишээнд ямар нэгэн зүйл хүний сэтгэлийг хөдөлдөг болохыг “хүрэх” үйл үгийг оюуншуулан илэрхийлсэн байна. Монгол хэлэнд мөн адил “сэтгэлд хүрэх” хэмээх үг байдаг бөгөөд энэ нь илүү санаанд нийцэх гэсэн утга илтгэдгээрээ утгын ялгаатай байна.

숨이 턱에 닿다 [сүми тогэ датта] энэ нь амьсгаа нь эрүүндээ хүрэх буюу ядарч туйлдсан гэсэн утга илтгэдэг байна. Жишээлбэл “아이들 뒷바라지하는 것도 이제 숨이 턱에 닿아서 못 하겠다. (СХСИТ)” Хүүхдүүдээ өсгөх гэж зүтгэсээр одоо ч бүр туйлдаад байна. Энэ нь тэр хэцүү мэдрэмж нэмэгдсээр хоолой цаашлаад эрүүнд хүртэл хүрсэн гэсэн санааг уг үгээр илэрхийлсэн байна.

#### **г. Цаг хугацаа илтгэсэн**

이마에 와 닿다 [имаэ ва датта] духанд хүрч ирэх гэсэн үг бөгөөд энэ нь цаг дөхсөн, ойртсон гэсэн утга илэрхийлдэг. Жишээнээс харвал “결혼 날짜가 이마에 와 닿았다. (СХСИТ)” Хуримын өдөр хаяанд ирлээ. Эндээс харвал бид цаг хугацааг гэрийн үүдэнд хаяанд ирлээ гэж ярьдаг бол солонгосчууд үүнийг өөрийн биеэ төв болгон үзэж “духанд хүрэх” гэсэн утгаар хийсвэрлэн илэрхийлдэг болох нь харагдаж байна. Мөн уг санааг 코 앞에 왔다 [ку апэ вадда] гэсэн үгээр илэрхийлдэг. Энэ нь хамрын урд буюу илт харагдахуйц ойрхон ирсэн, тулсан гэсэн санаагаар сэтгэж илэрхийлдэг нь ойртох гэсэн үйл үгийн хадгалахын сацуу орон байр заасан утгаа давхар хадгалсныг илтгэнэ.

Солонгос хэлний “хүрэх” үйл үгийн ангиллыг дараах схемээр нэгтгэн харуулав.



Зураг 3. Солонгос хэлний “당다/хүрэх” үйл үгийн утгын ангилал

## Дүгнэлт

Нэгдүгээрт, Монгол хэлний “хүрэх” үйл үгтэй нийлэмж үгсийн утга шилжих үзэгдлийг танин мэдэхүйн түвшинд солонгос хэлтэй харьцуулан судлаад танин мэдэхүйн болон, сэтгэлгээний адил тал болон ялгаатай талыг дараах байдлаар дүгнэж байна.

А. Монгол хэлнээ “хүрэх” үйл үгээр хүний сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгсийг монгол хэлэнд “хүрэх” гэсэн нэг үйл үгээр илэрхийлдэг бол солонгос хэлэнд уг санааг “나다”[нада]гарах, “생기다”[сэнгида] бий болох, өөр үйл үгээр гэсэн гурван янзаар илэрхийлдэг болох нь ажиглагдав. Үүнийг хүснэгтээр үзүүлвэл

Айдас Бөөлжис Инээд Дур Дургүй Зэвүү Уур Залхуу Хорхой Эгдүү Хөх инээд Хайр Зүрхэнд	<b>+ ХҮРЭХ</b>	1. 겁 멀미 웃음이 싫증이 화가 탐이 비웃음이 2. 혐오한 마음이 욕망이 3. 게으르다 사랑스럽다	+ 1. 나다/ + 2. 생기다 + 3. 동사 <b>үйл үг</b>
---	----------------	---	---


Хүснэгт 1 “Хүрэх үйл үгийн солонгос дүйцэл”

Энэ нь монголчууд аливаа юм ойрхон, тулж ирэх гэсэн утгаас оюуншуулан хийсвэрлэж тэрхүү мэдрэмж дотроос өөрт мэдрэгдэж ойртон, төрж буйг ① илэрхийлдэг бол солонгосчууд тэр мэдрэмж

дотроос гадагшаа гардаг ② хэмээн сэтгэн хийсвэрлэдэг нь хоёр ард түмний сэтгэлгээний ялгааны нэг илрэл болж байна.

Хоёрдугаарт. Утгын ангилал ба танихуйн онцлог.

А. “Хүрэх” үйл үгтэй нийлэмж үгсийн утгын хүрээ нь монгол, солонгос хэлэнд ойролцоо боловч бодит ба хийсвэр, ерөнхий ба тодорхойгоос хамаарсан ялгаа илэрч байна. ийг Хийсвэрлэн утгатай нийлэмж үгс монгол хэлэнд харьцангуй олон солонгос хэлэнд цөөн байгаа нь ажиглагдсан.



Зураг 1 “Хүрэх” үйл үгийн оюунишуулал

Б. Хоёр хэлнээ хийсвэр утга буюу сэтгэл хөдлөл илэрхийлсэн ангилал, орон зай, чиглэл заасан утга илтгэсэн ангиллууд байсан хэдий ч утгын хувьд өөр байв. Жишээлбэл чиглэл заасан ангилалд монгол хэлнээ “үгэндээ хүрэх”, “санасандаа хүрэх” гэх мэтээр хийсвэрлэн сэтгэж байгаа нь ямар нэг зүйлд хүрэхийг зорьж буй утга илэрхийлж байхад солонгос хэлэнд *길이 닿다* [гири датта] харилцаа холбоо тогтоох, *맥이 닿다* [мэги датта] холбогдох, *선이 닿다* [сони датта] нь холбоо харилцаатай гэх мэт хэн нэгэнтэй холбоо тогтоох харилцах гэсэн утга давамгайлж байгаа нь адилхан чиглэл зорих утга илтгэж байгаа боловч огт өөрөөр хийсвэрлэн сэтгэж байгаа нь харагдаж байна.

В. Монгол хэлний “хүрэх” үйл үгийн ангилалд сэтгэл хөдлөл илэрхийлсэн эерэг, сөрөг утгатай үг хамгийн олон байсан бол солонгос хэлэнд *가슴에 닿다* [касымэ датта] энэ нь сэтгэлд хүрэх буюу сэтгэл хөдлөх, *가슴에 와 닿다* [касымэ ва датта] зүрхэнд хүрэх гэсэн үгийг хийсвэрлэн сэтгэл хөдлөх гэсэн утга илэрхийлж, *숨이 턱에 닿다* [сүми тогэ датта] амьсгал эрүүнд хүрэх гэдэг үгийг оюуншуулан ядарч туйлдсан гэсэн гурван үг байдаг. Харин монгол хэлэнд эерэг ч бай сөрөг ч бай мэдрэмж илэрхийлсэн үгсийг “хүрэх” үйл үгээр илэрхийлж байгаа нь өөрийн биеэ танин мэдэх сэтгэлгээний ялгаа илэрч байна.

Г. Цаг хугацаа илэрхийлсэн үгс хоёр хэлэнд харьцангуй цөөн байв. Монгол хэлний “эрийн цээнд хүрэх”, “насанд хүрэх”, “хоёр нас хүрэх” нь цаг хугацаа илэрхийлж байгаа хэдий ч бид ямар нэг хэр хэмжээнд хүрэх хэмээн хийсвэрлэн сэтгэдэг бол солонгос хэлэнд *이마에 와 닿다* [има-э ва датта] дунханд хүрлээ буюу цаг дөхсөн, ойртсон гэсэн утга илэрхийлдэг тул уг үгийг тусад нь цаг хугацаа илэрхийлсэн ангилалд хамруулан авч үзсэн ч өөрөөр хэлбэл хийсвэрлэн сэтгэж буй байдал нь хоёр хэлэнд өөр байгаа нь ажиглагдав.

Д. Үйл үг төвтэй хэл болох монгол болон солонгос хэлний хүртэхүйн үйл үг “хүрэх” нь чиглэл заасан утга аль алинд нь хадгалж байгаа нь нийлэмж үйл үгийн шилжлэмэл утгаас нь илэрч, тухайн юм руу ойртон ирэх, үгүй бол бий болсныг илтгэж байгаагаараа нийтлэг байна.

## Ном зүй

Talmy, L. (2000). Typology and process in concept structuring. Toward a cognitive semantics Vol 2, 50-62.  
Ким, Ын. (2023). Монгол солонгос хэлний нийлэмж үгийн танихуйн онцлог. УБ хот: МУИС.  
Отгон-Эрдэнэ.Э. (2023). “Цаг” цогц ойлголт монгол хэлний баримтаар илрэх нь. УБ хот: МУИС.

- Өнөрбаян.Ц. (2022). Монгол хэл судлал XII “Өгүүлбэр зүй”. УБ хот: МУИС- МСХ.
- Туяа.Д. (2020). Үгийн утга шилжиж шинэ үг үүсэх нь . УБ хот: ШУТИС.
- 박영준, 최. (1997). 관용어사전. 서울: 태학사.
- 이승은. (2023). Монгол хэлний “дээр” хэмээх үгийн танин мэдэхүйн утга зүйн судалгаа. 몽골학회 제77호, 31-48.
- 임지룡. (1995). 국어 의미론 . 서울: 탑출판사.
- Н. Нансалмаа, С. Долгор (2021), “Танихуйн хэл шинжлэл”
- Ж. Баянсан (2022), “Монгол хэл судлал – Танихуйн хэл шинжлэл, хэлний соёл судлал XIV”
- Д. Бадамдорж (2018), “Танин мэдэхүйн утга зүйн удиртгал ”
- Д. Бадамдорж (2023), “Монгол хэлний утга зүйн судалгаа 1, 2”
- Г. Гантогтох (2020), “Монгол нүүдэлчдийн тайлбар толь III” -*Баяр, наадам, найр*-
- С.В. Киселёва (2011), “Когнитивная модель значения глагола”
- Плотникова А. М (2019), “Когнитивное моделирование семантики глагола”
- Langacker, R. W.(1987), Foundations of Cognitive Grammar: Theoretical Prerequisites Vol. 1. CA: University of Stanford Press. 이기동, 김종도 옮김(1991), 『인지문법』, 한신문화사.
- Taylor, J. R(2003). Cognitive Grammar. Oxford and New York: Oxford University Press.( 임지룡 · 김동환 역 2005. “인지문법”서울: 한국문화사.
- Zeki Hamawand – 임지룡, 윤희수 옮김 (2017), “의미론 -언어 의미의 인지적 설명”
- 김동환 옮김 (1998), 『인지언어학 개론』, 태 학사.
- 박수경 (2003), 동사 ‘とる’, ‘つかむ’, ‘잡다’의 인지적 비교, 대조 연구, 日本語教育 25,
- 변정민 (2001), 국어의 인지 동사 연구-동사적,의미적 특성을 중심으로. 고려대학교 대학원 박사학위
- 정영식(1999), 인지 문법의 의미 구조-인지 문법 중심으로-, 인문예술논총,제18집 , 169-199 pp

#### Хэрэглэгдэхүүн

- Ч. Лодойдамба “Тунгалаг тамир” роман (ТТ)
- Монголын уран зохиолын дээжис-108 боть (МУЗД)
- Монгол хэлний их тайлбар толь (МХИТТ)
- 표준대국어사전 Солонгос хэлний стандарт их толь (СХСИТ)
- 몽한대사전 Монгол солонгос их толь (МСИТ)
- Я. Цэвэл (2013), “Монгол хэлний товч тайлбар толь”(МХТТТ)
- <http://mongoltoli.mn>

#### Abstract

According to modern cognitive studies, Mongolian and Korean are both verb-centered languages in terms of typology. These languages typically do not use special words to indicate direction or spatial location; instead, such meanings are usually conveyed through the semantics of the verb itself. When this characteristic is viewed within the framework of complex linguistic structures, the development of metaphorical and extended meanings becomes clearly evident, providing insight into differences in Mongolian and Korean modes of thinking through practical examples.

For example, in Mongolian, the verb “хүрэх” (to reach) is abstracted from its original meaning of physical proximity or contact (to get close to or to touch), and this sense is used metaphorically to express internal feelings or sensations, such as “нойр хүрэх” (sleep reaches—meaning “to feel sleepy”) or “уур хүрэх” (anger reaches—meaning “to feel angry”). On the other hand, in Korean thought, such feelings are perceived as emerging from within and moving outward, and are thus expressed as “졸음이 오다” (sleep comes) or “화가 나다” (anger arises).

Moreover, while in Korean, the verb “닿다” (to reach or touch) is often used to express interpersonal contact or communication, in Mongolian, it is more commonly associated with the expression of sensations and emotional states. This observation highlights a distinct difference in how the two cultures conceptualize perception and emotion linguistically.

**Key words:** Cognition, perception, thinking/thought, conceptualization, touch/reach, to compare.